Батлан хамгаалахын сайдын нэрэмжит 2014 оны шилдэг бvтээлээр: “Батлан хамгаалах судлал” чиглэлээр цэргийн ухааны доктор, профессор Б.Шагдарын “Цэргийн урлаг: тvvх, сургамж” ном (2 боть), “Цэргийн зэвсэглэл, техник технологи” чиглэлээр доктор, профессор А.Хvv-Ухна, Г.Хvрэлбаатар нарын “Дарь, дарин бvтээгдэхvvн” бvтээлvvд тус тус шалгарлаа. Мон Батлан хамгаалах салбарын 2014 оны онцлох бvтээлээр “Батлан хамгаалах судлал” чиглэлээр тvvхийн шинжлэх ухааны доктор, профессор Х.Шагдарын "Энэ дэлхийд эгнэшгvй эцэг, хvv гурван жанжин: Сvбээдэй (1175-1248), Урианхайдай (1201-1273), Ачу (1233-1287)” номыг тодруулж Зэвсэгт хvчний офицер, ахлагч, Батлан хамгаалахын удирдлагын академийн сонсогчдын заавал судлах ном, бvтээлийн жагсаалтанд оруулахаар болов.